

Нэг. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Цаг агаар, орчны тоон загварчлал судалгааны хэлтэс (ЦАОТЗСХ)-ээс 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 2 дугаар саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг <http://www.tsag-agaar.mn/> цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Хүйтэн улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ЦАОТЗСХ-ээс тодруулах боломжтой.

Хоёр. ТОЙМ

2.1 Хүйтэн улирлын уур амьсгал


Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн 4 улирлын ялгаа ихтэй, хүйтний улиралдаа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага явдал юм. Тухайлбал 1940 оноос хойших мэдээгээр жилийн хамгийн хүйтэн үе болох 1 дүгээр сард агаарын үнэмлэхүй бага температур 1944-1945, 1956-1957, 1976-1977 оны өвөл Увс, Завхан, Баянхонгор, Хөвсгөлийн хойд хэсгээр $-45..-55^{\circ}\text{C}$ хүрсэн бол 1954 оны 12 дугаар сард Улаанбаатар хот орчмоор -49°C хүрч байв.

Агаарын температурын олон жилийн дундаж нь XI сард Баян-Өлгий, Завхан, Хөвсгөлийн ихэнх нутаг, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд, Хэнтийн баруун хойд хэсгээр $-16...-20^{\circ}\text{C}$, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсэг, Өмнөговь, Дорноговь, Дорнодын нутгаар $-2...-8^{\circ}\text{C}$, бусад нутгаар $-8...-16^{\circ}\text{C}$ хүйтэн байдаг. XII болон II сард Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр $-24...-30^{\circ}\text{C}$, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр $-8...-14^{\circ}\text{C}$, бусад нутгаар $-15...-23^{\circ}\text{C}$ хүйтэн байдаг. I сард Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр $-26...-32^{\circ}\text{C}$, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр $-10...-16^{\circ}\text{C}$, бусад нутгаар $-17...-25^{\circ}\text{C}$ хүйтэн байдаг байна.

Хур тунадас XI сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 6–8 мм, Их нууруудын хотгор болон говийн бүс нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–6 мм хур тунадас ордог байна. Харин XII болон II сард Их нууруудын хотгор болон говийн бүс нутгаар 0–2 мм, бусад нутгаар 3–6 мм цас ордог. I сард баруун болон говийн аймгуудын ихэнх нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–4 мм цас ордог байна.

2.2 Цас ихтэй жилүүдийн хүйтэн улирлын уур амьсгалын онцлог

1981–2021 оны хоорондох цаг уурын тулгуур 40 өртөөний тогтвортой цасан бүрхүүл тогтох хугацааг өргөргөөс нь хамааруулан зураг (1а)–д, цас ихтэй хүйтэн өвөл, цас ихтэй дулаан өвлийн агаарын температур, цасны зузааны хазайцын явцыг зураг (1б)–д тус тус үзүүлэв.




Зураг 1. а) Цасан бүрхүүл тогтвортой тогтох хугацаа, (өдөр). б) Хүйтэн улирлын (X-III) цас ихтэй дулаан (улаан шугам), цас ихтэй хүйтэн өвлийн (хөх шугам) агаарын температур ($^{\circ}\text{C}$), цасны зузааны (см) хазайц (1981-2019).

Зураг 1а–аас харахад манай орны хойд нутгаар ($> 47.5^{\circ}\text{N}$) X сарын сүүлээс эхлэн цасан бүрхүүл тогтдог бол нутгийн өмнөд хэсгээр ($< 45.0^{\circ}\text{N}$) XII сарын эхээр тогтдог байна. 1981–2021 оны хүйтэн улирлын (X–III сарын) цасны зузааны мэдээг байгалын ортигналь функцээр задлан шинжлэхэд 1 дүгээр эрэмбийн коэффициентийн (PCA1) их утгуудад их цастай жил тохиолдож байсан ба PCA1–ийн утгуудыг эрэмбэлэн цас ихтэй жилүүдийг түүвэрлэн авч хүйтэн улирлын агаарын температурын хазайцыг тооцон гаргахад 1981–2021 оны хооронд нийт 7 жилд (1983–1985, 1987–1988, 2009–2013) цас ихтэй хүйтэн өвөл (ОЖД–аас хүйтэн), харин нийт 5 жилд (1982–1983, 1992–1994, 1996–1997, 2001–2002) цас ихтэй дулаан өвөл (ОЖД–аас дулаан) тус тус тохиолдсон байна. Цас ихтэй дулаан жилүүдэд агаарын температур дунджаар ОЖД (1981–2010)–ийн орчим буюу $1\text{--}2^{\circ}\text{C}$ дулаан байхад цас ихтэй хүйтэн жилүүдэд агаарын температур дунджаар ОЖД–аас $1\text{--}3^{\circ}\text{C}$ хүйтэн байна (Зураг 1б).

Гурав. ХҮЙТЭН УЛИРЛЫН ТӨЛӨВ


3.1 2022 оны XI сараас 2023 оны II сарын цаг агаарын урьдчилсан төлөв

Арваннэгдүгээр сард. 2022 оны 11 дүгээр сарын агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–ийн орчим байх төлөвтэй байна (Зураг 2).




Зураг 2. 2022 оны 11 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв($^{\circ}\text{C}$)
[Н–агаарын температур ОЖД–ийн орчим]

11 дүгээр сарын нийлбэр хур тунадас Сэлэнгийн ихэнх, Төвийн зүүн хойд, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (Зураг 3).




Зураг 3. 2022 оны 11 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
[Н–хур тунадас ОЖД–ийн орчим, И–хур тунадас ОЖД–аас ахиу]

Арванхоёрдугаар сард. 2022 оны 12 дугаар сарын агаарын дундаж температур Сэлэнгийн ихэнх, Булган, Төвийн зүүн хойд, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (Зураг 4).




Зураг 4. 2022 оны 12 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв(°C)
[Н-агаарын температур ОЖД-ийн орчим, Х-агаарын температур ОЖД-аас хүйтэн]

12 дугаар сарын нийлбэр хур тунадас (цас) Баян-Өлгийн нутаг, Ховд, Говь-Алтайн ихэнх, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр ОЖД-аас бага, Хэнтий, Дорнодын нутаг, Сүхбаатарын хойд хэсгээр ОЖД-аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна **(Зураг 5)**.




Зураг 5. 2022 оны 12 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
[Б-хур тунадас ОЖД-аас бага, Н-хур тунадас ОЖД-ийн орчим, И-хур тунадас ОЖД-аас ахиу]

Нэгдүгээр сард. 2023 оны 1 дүгээр сарын агаарын дундаж температур Баян-Өлгийн нутаг, Увсын баруун, Ховд, Говь-Алтайн ихэнх, Баянхонгорын баруун өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр ОЖД-аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна **(Зураг 6)**.




Зураг 6. 2023 оны 1 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв(°C)
[Д-агаарын температур ОЖД-аас дулаан, Н-агаарын температур ОЖД-ийн орчим]

1 дүгээр сарын нийлбэр хур тунадас (цас) Увсын ихэнх, Завханы баруун хойд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна (Зураг 7).




Зураг 7. 2023 оны 1 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөө (мм)
[И–хур тунадас ОЖД–аас ахиу, Н–хур тунадас ОЖД–ийн орчим]

Хоёрдугаар сард. 2023 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас хүйтэн байх төлөвтэй байна (Зураг 8).



Зураг 8. 2023 оны 2 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөө(°C)
[X–агаарын температур ОЖД–аас хүйтэн]

2 дугаар сарын нийлбэр хур тунадас (цас) Увс, Завханы нутаг, Ховд, Говь-Алтайн зүүн хойд, Баянхонгорын хойд, Өвөрхангайн баруун хойд, Архангайн баруун өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна (Зураг 9).




Зураг 9. 2023 оны 2 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөө (мм)
[И–хур тунадас ОЖД–аас ахиу, Н–хур тунадас ОЖД–ийн орчим]

3.2 2022 – 2023 оны өвөл хаврын бэлчээрийн даац

Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2022–2023 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг брийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж гаргав.

Зуншлагын байдлыг 10 хоног тутамд үнэлсэн зургаас үзвэл 6 дугаар сарын 20-ноос 8 дугаар сарын 20-ны хугацаанд нийт нутгийн 50 орчим хувьд сайн, 40 гаруй хувьд дунд зэрэг, 10 орчим хувьд муу гэж үнэлэгдсэн байна (tsag-agaar.gov.mn).



Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн: 23.9 % - 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй), 15.6 % - 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй), 34.4 % - 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн), 7.7 % - 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн), 18.4 % - 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн) байна. Өөрөөр хэлбэл өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 40 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 60 гаруй хувьд хэтэрч гарлаа. Аймгийн дүнгээр авч үзвэл Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймгуудын ихэнх сум, багийн нутгаар даац хэтэрч гарсан байна.

Энэ жил баруун болон өмнө зүгийн нутгаар зуны турш гандуу болон гантай, баруун ба төвийн нутгаар сэрүүн, ялангуяа 7 дугаар сард олон жилийн дунджаас 1.1-3.7 градусуар сэрүүн байсан нь бэлчээрийн ургамлын ургалтанд таагүй нөлөөлж, нэгжийн ургац арви муутай гарч, улмаар бэлчээрийн даац ихээхэн хэтэрч гарах үндсэн нөхцөл болсон. Мөн хур тунадас хангалттай орж, зуншлага сайн байсан зарим нутагт даац хэтэрч гарсан нь малын тоо ахиу байгаатай холбоотой.

Бэлчээрийн даац олон дахин хэтэрч (улаан) гарсан сумдад Баян-Өлгийн Бугат, Алтанцөгц, Баяннуур, Сагсай, Увсын Сагил, Улаангом, Тариалан, Ховдын Эрдэнэбүрэн, Мянгад, Буянт, Ховд, Говь-Алтайн Хөхморьт, Жаргалан, Шарга, Баянхонгорын Гурванбулаг, Галуут, Бөмбөгөр, Баян-Овоо, Баянговь, Баянлиг, Өвөрхангайн Өлзийт, Баянгол, Төгрөг, Төвийн Баянхангай, Өмнөговийн Гурвантэс, Сэрвэй, Мандал-Овоо сумд хамрагдаж байна.

Харин Баян-Өлгийн Алтай, Дэлүүн, Ногооннуур, Булган, Увсын Бөхмөрөн, Ховд, Өмнөговь, Өлгий, Завхан, Хяргас, Ховдын Дөргөн, Мөст, Булган, Зэрэг, Завханы Баянтэс, Сонгино, Эрдэнэхайрхан, Алдархаан, Говь-Алтайн Тайшир, Баянхонгорын Хүрээмарал, Бууцагаан, Богд, Хөвсгөлийн Төмөрбулаг, Өвөрхангайн Уянга, Нарийнтээл, Богд, Сант, Булганы Баяннуур, Төвийн Дэлгэрхаан, Баяндэлгэр, Сүхбаатарын Түвшинширээ, Дундговийн Сайхан-Овоо, Өмнөговийн Ноён, Булган, Цогтцэций, Хүрмэн, Баяндалай, Ханбогд Дорноговийн Мандах, Сайхандулаан, Даланжаргалан сумдын нутгаар 3-5 дахин хэтэрч (улбар шар) гарлаа. Мөн нутгийн 34 хувьд даац **1-3 дахин хэтэрч** (шар) гарсан.

3.3 Гол мөрний мөсний үзэгдлийн прогноз

Монгол орны нийт гол мөрөнд 10 дугаар сарын сүүл үе ба 11 дүгээр сарын эхээр мөсний үзэгдэл ажиглагдаж эхлээд үндсэндээ 1 сарын хугацаанд мөсний үзэгдэл идэвхжсээр 11 дүгээр сарын сүүлээр битүү мөсөн бүрхүүл тогтдог. Харин энэ жилийн хувьд битүү мөсөн бүрхүүл тогтох хугацаа олон жилийн дундажтай харицуулахад Орхон голын нийт уртын дагууд, Хөвсгөлийн уулсаас эхтэй Эг, Бүгсий, Шишхэд, Идэр Хэнтий нуруунаас усжих

Туул, Тэрэлж, Сөгнөгөр, Хэрлэн голуудын хувьд 5-25 хоногоор хожуу ажиглагдах бол Хангайн нурууны өврөөс эхтэй Богд, Чигэстэй, Завхан, Түй, Таац, Байдраг, Онги мөн Алтайн нурууны Ховд, Буянт, Сагсай, Турган, Булган зэрэг голуудын хувьд битүү мөсөн бүрхүүл тогтох хугацаа олон жилийн дунджаас 5-10 хоногоор эрт ажиглагдана. Намрын мөсний үзэгдэл эхлэх хугацааны хувьд олон жилийн дунджийн орчим буюу дунджаас 5-10 хоногоор тус тус эрт эхлэх төлөвтэй байна. Зарим гол мөрний намрын мөсний үзэгдэл эхлэх, мөсөн бүрхүүл тогтох хугацааг хүснэгтэнд үзүүлэв.

Зарим гол мөрний намрын мөсний үзэгдэл эхлэх, мөсөн бүрхүүл тогтох хугацаа

д/д	Гол – Харуулын нэр	Олон жилийн дундаж хугацаа						2022 оны прогноз	
		Намрын зайр гүйж эхлэх			Мөсөн бүрхүүл тогтох			Мөсний үзэгдэл эхлэх	Мөсөн бүрхүүл тогтох
		дундаж	эрт	орой	дундаж	эрт	орой		
1	Сэлэнгэ мөрөн – Хутаг сум	X.23	X.04	XI.10	XI.21	XI.05	XII.22	X.21	XII.10
2	Сэлэнгэ мөрөн - Хялгант баг	X.27	X.12	XI.17	XI.25	XI.09	XII.20	X.23	XII.06
3	Эг гол - Эрдэнэбулган сум	X.23	X.06	XI.04	XI.22	X.23	XII.20	XI.04	XI.30
4	Эг гол - Хантай баг	X.22	X.07	XI.04	XI.12	X.31	XII.21	X.27	XII.12
5	Дэлгэрмөрөн – Мөрөн сум	X.15	IX.26	XI.01	XI.08	X.17	XI.28	X.25	XI.10
6	Идэр гол – Зүрх баг	X.19	X.01	XI.03	XI.11	X.21	XII.01	X.28	XI.24
7	Орхон гол – Орхон сум	X.21	X.03	XI.01	XI.17	X.16	XII.22	X.14	XI.30
8	Туул гол – Улаанбаатар хот	X.20	X.08	XI.10	XI.14	X.28	XII.01	X.24	XI.22
9	Хараа гол – Дархан	X.25	X.09	XI.06	XI.11	X.30	XI.27	XI.05	XI.25
10	Ерөө гол – Дулаанхаан	X.27	X.16	XI.05	XI.14	X.31	XI.03	X.28	XI.23
11	Хануй гол - Эрдэнэмандал сум	X.17	IX.22	XI.06	XI.11	X.27	XII.04	X.25	XI.21
12	Онон гол – Биндэр сум	X.21	X.08	XI.03	XI.13	X.29	XII.08	X.15	XI.22
13	Хэрлэн гол - Өндөрхаан	X.20	X.01	XI.07	XI.07	X.03	XII.05	X.30	XI.11
14	Хэрлэн гол – Чойбалсан	X.21	X.05	XI.08	XI.10	X.21	XII.25	X.31	XII.08
15	Халх гол – Сүмбэр сум	X.23	X.10	XI.16	XI.14	X.30	XII.01	X.15	XI.30
16	Богд гол – Улиастай сум	X.16	IX.25	XI.05	XI.16	X.24	XII.25	X.20	XI.10
17	Түй гол – Баянхонгор сум	X.25	X.06	XI.17	XI.23	X.24	XII.16	XI.01	XI.22
18	Ховд гол - Өлгий сум	X.17	X.01	XI.01	XI.05	X.17	XII.02	X.14	XI.05
19	Ховд гол – Мянгад сум	X.23	IX.22	XI.06	XI.23	XI.09	XII.21	X.14	XI.22
20	Буянт - -Ховд	X.23	IX.28	XI.11	XI.28	X.26	XII.20	XI.02	XII.20
21	Булган гол – Булган сум	X.21	X.01	XI.11	XI.22	X.26	XI.24	X.10	XI.28
22	Булган гол – Байтаг	X.28	X.01	XI.11	XI.27	XI.01	XI.30	XI.04	XII.02
23	Баруунтуруун – Баруунтуруун	X.12	X.01	X.28	XI.21	XI.24	XII.28	XI.01	XI.15
24	Боршоо – Боршоо	X.19	X.03	XII.01	XI.28	XI.07	XII.14	XI.16	XII.17

Дөрөв. ЗӨВЛӨМЖ

Агаарын дундаж температур: XI сард нийт нутгаар ОЖД–ийн орчим байх боловч XII сард нутгийн зүүн хойд хэсгээр, II сард ихэнх нутгаар **олон жилийн дунджаас хүйтэн**, харин I сард нутгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Хур тунадас: XI сард нутгийн зүүн хойд хэсгээр, XII сард зүүн зүгийн нутгаар, I сард Их нууруудын хотгор орчмоор, II сард Их нууруудын хотгор болон Хангайн уулархаг нутгаар **олон жилийн дунджаас ахиу**, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Өвөл хаврын бэлчээрийн даац нийт нутгийн 60 гаруй хувьд хэтэрч гарсан бөгөөд даац хэтэрч гарсан аймаг, сумдын нутагт өвс хадлан, нэмэгдэл тэжээл олж нөөцлөх, отор нүүдэл хийх, малаа борлуулах, тоог бууруулах зэрэг арга хэмжээ авч, өвөлжилт хаваржилтанд эртнээс бэлтгэх шаардлагатай байна.

Гол мөрний битүү мөсөн бүрхүүл 11 дүгээр сарын сүүлч болон 12 дугаар сарын эхний 10 хоногт тогтох төлөвтэй байгаа хэдий ч энэ жил гол мөрөн, нуурын мөсний зузааны даац хүн, мал, машин техник явахад аюулгүйн хэмжээнд хүрч чадахгүй байх магадлалтайг анхаарч, мөс цөмрөх аюулаас болгоомжлохыг анхааруулж байна.